



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

□ Байрны бохирын шугам засварлахад
шаардлагатай хөрөнгө гаргах тухай □

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 1 дүгээр хорооны 6 дугаар байрны бохирын шугам хуучирч муудан хотойлт үүсэж, муу ус алдагдан бохир ихээр үнэртэж, оршин суугчдын эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн тул бохирын шугам хоолойг засварлаж, солих, бохир соруулах, ариутгах ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг Ус суваг ашиглалтын товчоо (Н.Батсайхан)-нд үүрэг болгосугай.

2. Засварын ажилд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, 2,269,000 (Хоёр сая хоёр зуун жаран есөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Ус суваг ашиглалтын товчоо (Н.Батсайхан)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төхижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 06 ны өдрийн 12 дугаар
захирамжийн хавсралт



БАЙРНЫ БОХИРЫН ШУГАМ ЗАСВАРЛАХАД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Хуванцар хоолой (Ф100)	у/м	30	18,000	540,000
2	Булан (45 градус Ф100)	ш	6	7,000	42,000
3	Булан (90 градус Ф100)	ш	5	7,500	37,500
4	Ризны таг (Ф100)	ш	4	5,500	22,000
5	Троник (Ф100)	ш	7	10,500	73,500
6	Татуурга хомут (Ф100)	ш	30	11,000	330,000
7	Анкар төмөр резватай (Ф10)	м	30	12,000	360,000
8	Анкар бетонон тэлэгч (Ф12)	ш	40	7,000	280,000
9	Ариутгалын хувцас (Иж бүрэн)	ком	6	30,000	180,000
10	Резинэн бээлий	ш	8	4,500	36,000
11	Бензин (АИ-92)	литр	25	2,380	59,500
12	Лагийг хусаж цэвэрлэх (ариутгал халдваргүйжүүлэх бодис-уураар утагч)	М ²	25	8,500	212,500
13	Хордлого тайлах сүү	ш	16	6,000	96,000
Нийт үнэ:					2,269,000